



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
 ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ
 ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
 ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
 ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
 ЗАСАГ ДАРГЫН
 ЗАХИРАМЖ**

᠒᠐᠒᠒ оны 08 сарын 03 өдөр

Дугаар А/НЗД

Алтай хот

┌ Тусгай зөвшөөрөл олгох тухай ┐

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсэг, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Согтууруулах ундааны худалдаа, үйлчилгээнд тавигдах шаардлагыг хангаж, спиртийн өндөр болон сул агууламжтай согтууруулах ундаагаар худалдах, үйлчлэх тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулахаар материалаа ирүүлсэн аж ахуйн нэгжийг хавсралтаар баталсугай.

2.Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд хяналт тавьж, хууль тогтоомж, шаардлага журмыг зөрчсөн тохиолдолд зөвшөөрлийг хүчингүй болгох арга хэмжээ авч ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар (Н.Сумъяабазар), Цагдаагийн газар (Н.Эрдэнэ-Очир), холбогдох сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Г.Чинбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

О.АМГАЛАНБААТАР



Аймгийн Засаг даргын 2020 оны
08 дугаар сарын 03-ны өдрийн 4 дугаар
захирамжийн хавсралт

СПИРТИЙН ӨНДӨР БОЛОН СУЛ АГУУЛАМЖТАЙ
СОГТУУРУУЛАХУНДАА ХУДАЛДАХ, ҮЙЛЧЛЭХ ТУСГАЙ
ЗӨВШӨӨРЛИЙГ СУНГАСАН АЖ АХУЙН НЭГЖҮҮД

| Д/д | Сумын харьяалал | Аж ахуйн нэгжийн нэр | Дэлгүүр, үйлчилгээний газрын нэр | Байрлал | Худалдаа үйлчилгээний хэлбэр |
|-----|-----------------|----------------------|----------------------------------|-----------|------------------------------|
| 1. | Алтай сум | "Аж алтан нутаг" ХХК | Алтан нутаг хүнсний дэлгүүр | Сумын төв | Худалдах |
| 2. | Цээл сум | "Суман таян" хоршоо | Суман таян хүнсний дэлгүүр | Сумын төв | Худалдах |
| 3. | Цээл сум | "Суман таян" хоршоо | Залуус караоке | Сумын төв | Үйлчлэх |
| 4. | Цээл сум | "Таян баялаг" ХХК | Мөст хүнсний дэлгүүр | Сумын төв | Худалдах |

__оОо__